



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/37

Хэрлэн сум

Байгууллагын үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн

ахлагч:

Ж.Гантулга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Ш.Эрдэнэжаргал

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Б.Дарханбаатар

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Э.Мөнх-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Д.Өнөрцэцэг

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Н.Хүрэлээ

Цэргийн штабын дарга

Ц.Ганчимэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

2.Үнэлгээний багийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг байгууллагын үнэлгээний багийн ахлагч (Ж.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР